



МОНГОЛ УЛСЫН
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 04

Улаанбаатар хот

Төв комисс байгуулах тухай

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Гадаад харилцааны яамны 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08/393 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий Төв комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

Н.Анхбаяр

Гадаад харилцааны яамны
Төрийн нарийн бичгийн дарга

Нарийн бичгийн дарга:

С.Золжаргал

Гадаад харилцааны яамны
Төрийн захиргааны удирдлагын
газрын захирал

Гишүүд:

Д.Баяндүүрэн

Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн
бөгөөд Ажлын албаны дарга

Т.Нармандах

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
Иргэний улсын бүртгэлийн газрын дарга

Р.Бизьяа

Гадаад харилцааны яамны
Төрийн захиргааны удирдлагын
газрын Хуулийн хэлтсийн дарга

С.Алтангэрэл

Гадаад харилцааны яамны Төрийн
захиргааны удирдлагын газрын Санхүү,
эдийн засгийн хэлтсийн нягтлан бодогч

Н.Батаа

Гадаад харилцааны яамны
Консулын газрын зөвлөх


2. Гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулсан, салбар комиссыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Төв комисс /Н.Анхбаяр/-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хорооны нарийн бичгийн дарга /Д.Даваа-Очир/-тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

П.ДЭЛГЭРНАРАН

Д.ДАВАА-ОЧИР



0000008